



**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2021 оны 08 сарын 17 өдөр

Дугаар 86

Даланзадгад сум

“Сүү, тараг” хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2. “ж”, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 2/4 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Сүү, тараг” хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган, хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгаж, үр дүнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга /Р.Сэддорж/-д даалгасугай.

3. Эрүүл мэнд, хөдөө аж ахуйн салбар, төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн хамтын оролцоонд тулгуурлан хөтөлбөрийг хэрэгжүүлж, үр дүнг нэгтгэн жил бүрийн нэгдүгээр улиралд багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг дарга /Р.Сэддорж/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.БАДРАА

462210192



“Сүү, тараг” хөтөлбөр (2021-2024 он)

Нийтлэг үндэслэл:

Бага насны хүүхдийн бие бялдар, оюуны хөгжлийг бүрэн тэтгэж, эсэн мэнд амьдрах, цаашид урт удаан хугацаанд эрүүл саруул байлгах гол нөхцөл нь тэднийг амьдралын эхний үе шатнаас зөв зохистой хооллож, шимт бодисыг хэрэгцээт хэмжээгээр хангах юм. Хүний амьдралын эхний 1000 хоногт буюу эх жирэмсэлснээс эхлэн 2 нас хүртэлх хугацаанд хоол тэжээлийн дуталд өртөх нь хожмын эргэшгүй хүнд өөрчлөлт болох өсөлтийн хоцролтой болоход хүргэнэ. Хүнсний хүртээмж, тэжээллэг чанар муу байх, шим тэжээлийг шингээх чадамжгүй болох нь дэлхийн хүн амын нилээн хэсгийг хоол тэжээлийн дутал, аминдэм, бичил бодисын дутал, илүүдэл жин таргалалт, хүн амын бүлгийн ялгаатай байдлыг үүсгэж байна.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ), Нэгдсэн үндэстний байгууллага (НҮБ)-ын Хүүхдийн сангаас санаачлан бага насны хүүхдийн хооллолтын зөв дадлыг дэмжихэд улс орнуудын анхаарлыг хандуулах зорилгоор “Нялх, бага насны хүүхдийн хооллолтыг дэмжих дэлхийн стратеги”-ийг боловсруулж, 2002 онд ДЭМБ-ын 55 дугаар чуулганаар баталсан. Нялх, бага насны хүүхдийн хооллолтыг дэмжих дэлхийн стратегид “Эхийн сүү нь хүүхдийн бие махбодийн хэвийн өсөлт, хөгжилтийг хангахад зориулагдсан төгс найрлагатай юугаар ч орлуулшгүй бүтээгдэхүүн болохоос гадна эхийн эрүүл мэндийн хамгийн чухал нөхөн үржихүйн үйл ажиллагааны салшгүй хэсэг мөн” гэж заасан ба ДЭМБ-ын зөвлөмжид.

Хүүхдийг эхээс мэндэлмэгц эхний нэг цагийн дотор буюу аль болох эрт ангир уургийг амлуулах;

Хүүхдийг 6 сар хүртэл эхийн сүүгээр дагнан хооллох ба өөр ямар нэгэн сүү, тэжээл, ус зэргийг өгөхгүй байх;

Хүүхдийг 6 сар хүрмэгц үргэлжлүүлэн хөхүүлэхийн зэрэгцээ аюулгүй, тохирсон нэмэгдэл хоолонд оруулах;

Хоёр ба түүнээс дээш насанд үргэлжлүүлэн хөхүүлэхийн зэрэгцээ тохирсон нэмэгдэл хоолоор хооллоно гэж заасан.

Монголын хүүхдийн хоол тэжээлийн байдал:

Сүүлийн 10 жилийн хугацаанд Монголын 5 хүртэлх насны хүүхдийн хоол тэжээлийн дутлын үзүүлэлтүүд буурснаар хүн амын хоол тэжээлийн байдалд эерэг өөрчлөлт бий болсон. 2020 оны байдлаар 5 хүртэлх насны хүүхдийн 10.8 хувь нь өсөлт хоцролттой, 1.6 хувь нь тураалтай, 1.0 хувь нь туранхай, 16.7 хувь нь илүүдэл жин ба таргалалттай байна.

Үндэсний түвшинд хоол тэжээлийн байдлын үзүүлэлт сайжирсан хэдий ч бүс нутаг, нийгэм эдийн засгийн хувьд ялгаатай байдал байсаар байна. Тухайлбал 5 хүртэлх насны хүүхдийн дундах өсөлт хоцролтын тархалт баруун бүсэд 19.5 хувь, зүүн бүсэд 13.5 хувь байгаа бол Улаанбаатар хотод 7.1 хувь байна.

Хүн амын дунд ядуурал төдийлөн сайн буураагүй учраас эдийн засгийн хямрал, хүнсний хомсдол, гамшиг, цар тахал, онцгой байдлын үед хүүхдийн хүнс, тэжээлээс шалтгаалсан туранхай, тураал, жингийн алдагдал нэмэгдэх магадлал өндөр байна.

Өмнөговь аймгийн хэмжээнд 2021 оны 1 дүгээр улирлын байдлаар 1680 эх төрж өнгөрсөн оноос 2,3% буюу 39 тохиолдлоор өссөн байна. Нийт төрсөн хүүхдийн 4,4% буюу 75 тохиолдол нь 2,500-с доош жинтэй төрсөн байна. 6-12 сартай 1350 хүүхэд, 2 хүртэл насны ихэр 62 хүүхэд, 17 хүртэл насны хөгжлийн бэрхшээлтэй 270 хүүхэд, жингийн алдагдалтай, өсөлтийн хоцролтой 120 хүүхэд буюу нийт 1802 хүүхдийн судалгаа гарч байна. Дээрх тоон үзүүлэлтээс харахад нийт хүүхдийн 2.1% буюу 120 хүүхэд жингийн алдагдалтай байгаа нь улсын дунджаас 0,5%-р их байна. Жингийн алдагдалтай хүүхдийн

гол шалтгаан нь суурь өвчлөл, хоол тэжээлийн дутагдлаас болж байна. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн ясны бүтцийн бат бөх байдал нь алдагдсан зэрэг олон асуудал тулгамдаж байгаа нь энэхүү хөтөлбөрийг боловсруулах гол үндэслэл болж байна.

Эхийн сүүгээр хооллолт:

Монголчууд хүүхдээ эхийн сүүгээр хооллодог эртний уламжлалтай. Манай улсын эхийн сүүгээр хооллолтын үзүүлэлт бүс нутаг ба дэлхийн түвшинд сайн гэж үнэлэгддэг ч сүүлийн жилүүдэд буурах хандлагатай болжээ. 6 хүртэлх сартай хүүхдийг эхийн сүүгээр дагнан хооллох үзүүлэлт 2000 оноос хойшх 10 гаруй жилд харьцангуй тогтонги (55-60 хувь) байсан ч, 2020 онд 47 хувьд хүрч буурчээ.

Хүүхдийн нэмэгдэл хоол:

6-12 сартай хүүхдийн 98.4 хувь, 25-59 сартай хүүхдийн 99.9 хувь, 12-23 сартай бүх хүүхдүүд ДЭМБ болон Эрүүл мэндийн яамны зөвлөмжийн (хэмжээ, давтамж) дагуу хооллож чадахгүй байна. Мөн Монгол хүүхдийн нэмэгдэл хоолны давтамж, нэг удаад идэх хэмжээ хангалтгүйгээс гадна илчлэг ихтэй, шим тэжээл багатай байна. Зохих давтамжийн дагуу нэмэгдэл хоолоор хооллож байгаа 6-23 сартай хүүхэд 2010 онд 30 хувь, 2020 онд 35 хувь байна.

Аминдэм бичил бодисын дутал, хангалт, хүнс баяжуулалт:

Хүүхэд, эмэгтэйчүүдийн дунд амин дэм, эрдэс бодисын дутал буурахгүй байна. Тухайлбал 5 хүртэлх насны хүүхдийн 32.3 хувь нь А амин дэмийн дуталтай, 21.8 хувь нь Д амин дэмийн дуталтай, 28.5 хувь нь цус багадалттай, 21.4 хувь нь төмрийн дуталтай байна.

Аймгийн хэмжээнд хүүхдийн хоол тэжээлийн төвлөрсөн үйлчилгээ бий болоогүй мөн хүүхдийн хоол тэжээлд сүү, сүүн бүтээгдэхүүн /тараг, ээдэм/ жимс, хүнсний ногоо /нухаш, зутан/ олон төрлийн бүтээгдэхүүнээр хооллох боломж хязгаарлагдмал байгаа нь бага насны хүүхдийн хоол, тэжээлийн дутагдалд орох нөхцөл байдлыг үүсгэж байна.

Иймд говь нутгийн ирээдүй болсон хүүхдийн хэвийн өсч бойжих, нөхцөлийг дэмжих зорилгоор Өмнөговь аймгийн хэмжээнд "Сүү, тараг" хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх хэрэгцээ байна.

Нэг. Хөтөлбөрийн зорилго:

1.1. Аймгийн хэмжээнд зорилтот бүлгийн бага насны хүүхдийн өсөлт хөгжилт, хөгжлийн бэрхшээлтэй байнгын асаргаатай хүүхдийн хоол тэжээлийг дэмжиж чанарлаг, амин дэмээр баялаг сүү, сүүн бүтээгдэхүүнээр хангаж, хүүхдэд ээлтэй хоол тэжээл, сувиллын үйлчилгээг үзүүлснээр бие бялдрын өсөлт, дархлааг дэмжиж хүүхдийн хоцрогдол, өвчлөл, эндэгдлийг бууруулна.

Хоёр. Хөтөлбөрийн зорилт:

2.1. Зорилт 1. Бага насны 06-12 сартай хүүхэд, 12 хүртэл насны хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, 2 хүртэл насны ихэр хүүхэд, жингийн алдагдалтай, өсөлтийн хоцролттой, эмзэг бүлгийн хүүхдийг сүү, сүүн бүтээгдэхүүнээс авах амин дэм эрдэс тэжээлээр хангах.

2.2. Зорилт 2. Хүүхдийн сүүний газар, үйлдвэрлэлийг бодлогоор дэмжих тогтвортой, найдвартай ажиллах нөхцөл бололцоог бүрдүүлэх, аюулгүй байдлыг хангах, нэр төрлийг нэмэгдүүлэх, амин дэмийн дутал, өсөлт хоцрогдлыг бууруулах.

2.3. Зорилт 3. Бага насны хүүхэдтэй эцэг, эхийн хоол тэжээл, асаргаа сувилгааны талаарх мэдлэг боловсролыг нэмэгдүүлэх, салбар хоорондын хамтын ажиллагааг сайжруулах.

Гурав. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

3.1. Хөтөлбөрийн 1 дүгээр зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

3.1.1. “Сүү, тараг” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хэсгийг аймаг, сумын Засаг даргын захирамжаар баталж, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан ажиллах, хэрэгжилтэд хяналт тавих;

3.1.2. Хөтөлбөрийн зорилго, зорилт, чиглэлийг хэрэгжүүлэгч байгууллага нь төрийн болон төрийн бус байгууллага, хамтрагч талуудыг мэдээллээр хангах, сургалт хийх, хэрэгжүүлэх;

3.1.3. Зорилтот бүлгийн (6-12 сартай, 2 нас хүртэлх ихэр хүүхэд, 12 нас хүртэлх хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй, жингийн алдагдалтай, өсөлтийн хоцролтой) хүүхдийн судалгааг сум, өрхийн эмнэлэг, халамжийн байгууллагатай хамтран хүүхдийг нэрээр гаргах, шилжилт хөдөлгөөнийг хийх, баталгаажуулах, мэдээг сар бүр гаргах;

3.1.4. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны журмыг боловсруулан батлуулах, эцэг эхчүүдэд мэдээлэл өгөх, батлагдсан журмыг танилцуулж ойлгуулах, сурталчлах;

3.1.5. Хөтөлбөрт хамрагдах зорилтот бүлгийн хүүхдийг сум, өрхийн эмчийн үзлэгт хамруулж, сүү, тараг олголтын дэвтэр олгох, тэмдэглэгээ хийх, баталгаажуулах, эрүүл мэндийн үзүүлэлтийн мэдээ гаргах;

3.1.6. Хөтөлбөрт хамрагдвал зохих хүүхдэд сүү, тараг, аминдэмээр хангах, хөдөөний малчны хүүхэд, алслагдсан бүс нутгийн хүүхдийг амин дэм, нэмэлт тэжээлээр хангах;

3.1.7. Сүү, таргийг хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчдад олгох, амин дэм, олон найрлагат тэжээлээр хангах, олгох, хүүхдийн өсөлт хөгжилтийг хянах, эмчийн үзлэгт тодорхой хугацаанд хамруулах, зөвлөгөө авах, мэдээллээр хангах;

3.1.8. Зуны улиралд сүү, тараг хөтөлбөрийн хүрээнд хүүхдийн сувилал, сувиллын үйл ажиллагаа явуулах, чийрэгжүүлэх, сурталчлах;

3.1.9. Өрхийн эмнэлгийн хяналтад байгаа, байнгын оршин суух хаягтай 06-12 сартай хүүхдүүдийг хөтөлбөрт үе шаттайгаар хамруулах.

3.2. Хөтөлбөрийн 2 дугаар зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

3.2.1. Хүүхдийн сүү, сүүн бүтээгдэхүүний аюулгүй байдал, бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх, хүүхдийн сүүний газрын удирдлага, ажилчдыг мэргэжлийн сургалтад хамруулахыг дэмжих;

3.2.2. Хүүхдийн сүүний газар болон сүү, сүүн бүтээгдэхүүн, тараг нийлүүлэх иргэн, аж ахуй нэгжийн судалгаа гаргах, сонгон шалгаруулах, бүтээгдэхүүн нийлүүлэх, хамтран ажиллах гэрээ хийх;

3.2.3. Бүтээгдэхүүн нийлүүлэх аж ахуй нэгж, сүүний ферм, сүү түгээгч, иргэд бүтээгдэхүүний чанарын баталгаажилт, малын шинжилгээ, ажилчдын эрүүл мэндийн шинжилгээний бичиг, холбогдох шаардлагатай бичиг, баримтын баталгаажилт хийх;

3.2.4. Гүйцэтгэгч аж ахуй нэгж, иргэн нь сүү, тараг олгох бүрт батлагдсан олгох дэвтэрт тэмдэглэл хийх, бүртгэлийн цахим систем нэвтрүүлэх, эцэг эхэд мэдээлэл, сургалт, сурталчилгааг хийх;

3.2.5. Сүү, сүүн бүтээгдэхүүн, тарагны нэр төрлийг нэмэгдүүлэх, үнийг тогтвортой байлгах;

3.2.6. Сүүний бизнес эрхлэлтийг дэмжих, сүүний үйлдвэр цех байгуулахад дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааг тогтмолжуулах, үйлчилгээг өргөжүүлэх;

3.2.7. Сайн туршлага, шинэ технологи, инновацыг дэлгэрүүлэх, дэмжих, сурталчлах;

3.3. Хөтөлбөрийн 3 дугаар зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

3.3.1. Иргэд, эцэг эхчүүдэд хүүхдийн зөв хооллолтын талаархи мэдээлэл сургалт сурталчилгааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмолжуулах;

3.3.2. Эрүүл мэндийн байгууллага нь өрх гэр, олон нийтэд түшиглэн бага насны хүүхдийн хоол тэжээл, нэмэгдэл хоолны талаар сургалтуудыг тасралтгүй хийх, мэдлэг хандлагыг сайжруулах, гарын авлагаар хангах;

3.3.3. Бага насны хүүхэдтэй эцэг, эхийн хоол тэжээл, нэмэгдэл хоол, сүү, тараг, аминдэмийг зөв, зохистой хэрэглэх, асаргаа сувилгааны талаарх мэдлэг боловсролыг нэмэгдүүлэх сургалт хийх;

3.3.4. Сум, өрхийн эмнэлэг, төрийн байгууллага, хамтрагч тал, бизнес эрхлэгчдийн хамтын ажиллагааг сайжруулах;

3.3.5. Хүүхдийн сүү, сүүн бүтээгдэхүүний аюулгүй байдал, бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх, хүүхдийн сүүний газрын эрхлэгч, үйлдвэрийн ажилчдыг мэргэжлийн сургалтад хамруулахыг дэмжих;

Дөрөв. Хөтөлбөрийн хэрэгжих хугацаа:

4.1. Хөтөлбөрийг аймгийн хэмжээнд 2021-2024 онд үе шаттай хэрэгжүүлнэ. (жилд 6 сар байх)

Тав. Хамрах хүрээ:

5.1. "Сүү, тараг" хөтөлбөрт зөвхөн Өмнөговь аймгийн үндсэн бүртгэлтэй, сум өрхийн эрүүл мэндийн төвд тогтмол хяналтад байдаг хүүхдүүд хамрагдана.

5.1.1. 06-12 сартай зорилтот бүлгийн хүүхэд;

5.1.2. 2 хүртэл насны ихэр хүүхэд;

5.1.3. 12 хүртэл насны хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй байнгын асаргаатай хүүхэд;

5.1.4. Жингийн алдагдалтай, өсөлтийн хоцролтой хүүхэд;

Зургаа. Хөтөлбөрийн санхүүжилт

6.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

6.1.1. Улсын болон орон нутгийн төсөв;

6.1.2. Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив;

6.1.3. Бусад эх үүсвэр;

Долоо. Хөтөлбөрийн удирдлага зохион байгуулалт:

7.1. Хөтөлбөрийн үйл ажиллагааны нэгдсэн удирдлага, зохицуулалтыг аймгийн Засаг даргын Тамгын газар /Нийгмийн бодлогын хэлтэс/, хөтөлбөрийн ажлын хэсэг зохион байгуулна.

7.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх, эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулах, мэдээллээр хангах, удирдлага арга зүйгээр хангаж, хэрэгжүүлж, тайлагнаж ажиллах нь Эрүүл мэндийн газар хариуцан гүйцэтгэнэ.

Найм. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төрийн байгууллага болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн оролцоо, үүрэг:

8.1. Сумын Засаг даргын Тамгын газар:

8.1.1. Сүү, тараг нийлүүлэх аж ахуй нэгж, иргэнийг сонгон шалгаруулах, хамтран ажиллах гэрээ байгуулах, ажлын хэсгийг бодлого арга зүйгээр хангах;

8.1.2. Хөтөлбөрийн үр дүнтэй хэрэгжүүлэхэд дэмжлэгт удирдлагаар хангах, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх;

8.1.3. Сайн, шинэлэг санааг нэвтрүүлэн хэрэгжүүлэх, сурталчлах, мэдээлэх;

8.2. Эрүүл мэндийн байгууллагууд:

8.2.1. Өрх, сумын эмнэлгийн эмч, мэргэжилтэн хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд тодорхой албан тушаалтанд хариуцуулах, байгууллагуудыг арга зүйгээр хангах;

8.2.2. Өрх, сумын эмнэлэг хөтөлбөрт хамрагдсан хүүхдийн өсөлтийг тодорхой давтамжтай үзэж үнэлэх, дэвтэрт тэмдэглэх, тоон мэдээг сар бүр үнэн зөв гаргаж ЭМГ-т мэдээлэх, хөтөлбөрт хамрагдсан хүүхдийн эрүүл мэндийн мэдээллийн сан үүсгэх;

8.2.3. Хөтөлбөрийн хэрэгжилтэд ЭМГ-ын хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн хяналт тавих, тоон мэдээг нэгтгэж тайлагнах, нотолгоонд суурилсан судалгааг хийх, бүх шатны байгууллагуудыг мэдээллээр хангах;

8.3. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар:

8.3.1. Сүү, тараг хөтөлбөрт хамрагдах болон хамрагдаж буй хүүхдийн судалгааг гаргахад ЭМГ-тай хамтарч ажиллах;

8.3.2. Зорилтот бүлгийн хүүхдүүдийг хөтөлбөрийн хамрагдалтад сар бүр хяналт тавих;

8.3.3. Үйлчилгээ авч буй эцэг, эх, асран хамгаалагч нараас хэрэглэгчийн үнэлгээ авах;

8.4. Мэргэжлийн хяналтын газар:

8.4.1. Сүү, сүүн бүтээгдэхүүний чанар, хүнсний эрүүл ахуй, химийн болон бусад амт оруулагч нэмэлт бүтээгдэхүүн хэрэглээгүй, найрлагад хяналт тавих, зөвлөмжөөр хангах;

8.4.2. Сүү, сүүн бүтээгдэхүүний шинжилгээ, нийлүүлэгч аж ахуй нэгжид хамтарсан хяналт үнэлгээг хийх;

8.5. Хүнс, хөдөө аж ахуйн газар:

8.5.1. Сүү, сүүн бүтээгдэхүүн нийлүүлэх аж ахуй нэгж, иргэдийн судалгаа гаргах, хөтөлбөрийн ажлын хэсэгт зөвлөх;

8.5.2. Сүү, тарагны үйлдвэр, цех шинээр байгуулахад бизнес эрхлэгчдэд мэргэжлийн зөвлөмжөөр хангах, хүчин чадал, хэрэгцээ шаардлагыг тодорхойлох;

Ёс. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ:

9.1. Хөтөлбөрийн хэрэгжилтэд сар бүрийн аймгийн Эрүүл мэндийн газар, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, тухайн сумын Тамгын газар хяналт хийж байна.

9.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг жил бүр аймгийн Засаг даргын Тамгын газрын холбогдох хэлтэс хариуцан зохион байгуулна.

9.3. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс хэрэгжилтийн тайланг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд танилцуулна.

Арав. Хөтөлбөрөөс гарах үр дүн, шалгуур үзүүлэлт:

10.1. Эрүүл мэндийн байгууллагаас хүүхдийн эрүүл мэндийн байдалд тогтмол хяналт тавьж, хоол тэжээлийг дэмжсэнээр бага насны хүүхдийн өсөлт, хөгжилтийг дэмжиж, өвчлөл эндэгдлийг бууруулна.

10.2. Сүү, сүүн бүтээгдэхүүнийг хүүхэд бүрд тогтмол хэрэглүүлснээр ясны сийрэгжилт, цус багадалт, хоол тэжээлийн дутлаас үүсэх өвчлөлийг бууруулах, шүдний өвчлөлөөс урьдчилан сэргийлэхэд томоохон дэмжлэг үзүүлнэ.

10.3. Бага насны хүүхдүүд сүү, сүүн бүтээгдэхүүнээс нэг өдөрт авах норм, амин дэмээ бүрэн авна. (1 өдөрт 200 гр сүү, сүүн бүтээгдэхүүн хэрэглэх нормтой, 200 гр эко сүү, сүүн бүтээгдэхүүнээс хүүхэд 100 төрлийн амин дэм авч чадна)

10.4. Сүү, тараг хөтөлбөрт тураалтай, туранхай, хоцролтой хүүхдүүд хамрагдах бөгөөд тэдгээр хүүхдүүдийн 90-ээс дээш хувийг дээрх шалтгаанаас гаргах зорилгоор ажиллана.

10.5. Сүү, тараг хөтөлбөрийг өмнө хэрэгжүүлсэн туршлагад суурилан шинэлэг байдлаар хэрэгжүүлнэ. (цахим бүртгэлийн систем, сар бүрийн мэдээг имфогарфик ашиглан мэдээлэх)

10.6. Сүү, тараг хөтөлбөрт хамрагдаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн дунд тулгамдаж байгаа асуудлын судалгааг хийсэн байна.

10.7. Орон нутгийн сүү, сүүн бүтээгдэхүүн нийлүүлэгчдийг бодлогоор дэмжих, хүүхдийн сүүний үйлдвэртэй болох боломжтой болно.

10.8. Зуны сувилалтай хавсарч хэрэгжүүлснээр бага насны хүүхдийн биеийн дархлаа сайжирч улирлын томуу буурна.

10.9. Сүү, тараг хөтөлбөрт хамрагдаж байгаа хүүхдүүдийн эцэг, эхийн эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлнэ.

10.10. Сүү, тараг хөтөлбөр нь эх хүүхдийн эрүүл мэнд, эрүүл шүд хөтөлбөрүүдтэй уялдан хэрэгжүүлж илүү үр дүн гаргана.

Шалгуур үзүүлэлт:

№	Үзүүлэлт	2016 оны суурь түвшин (%)	2024 оны зорилтот түвшин (%)	Эх сурвалж
1	Хугацаандаа нэмэгдэл хоолонд орсон хүүхдийн эзлэх хувь (6-8 сартай)	78	85	Статистикийн үзүүлэлтийн түүвэр судалгаа
2	Өдөрт 4 ба түүнээс дээш олон нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүн хэрэглэж байгаа хүүхдийн эзлэх хувь (6-23 сартай)	30	55	
3	Хөтөлбөрт хамрагдаж байгаа хүүхдийн тураал	20	10	
4	Хөтөлбөрт хамрагдаж байгаа хүүхдийн туранхай	40	25	Хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн судалгаа
5	Хөтөлбөрт хамрагдаж байгаа хүүхдийн өсөлт хоцролт	10	8	
6	Хөтөлбөрт хамрагдаж байгаа нийт хүүхдийн хамралтын хувь	92,8	95,8	
7	Хөтөлбөрт хамрагдаж байгаа хүүхдийн ар гэрийнхнээс авах сэтгэл ханамжийн судалгаа. (түүврийн аргаар, өмнөх онд авч байсан асуумжаар авна)	82	92	
8	Хөтөлбөрийг зуны сувилалтай хавсарч хэрэгжүүлсэн байгууллагын тоо	13	17	
9	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тулгамдаж байгаа асуудлын судалгааг хийх	0	95	
10	Хөтөлбөрийн хэрэгжилт	87.3	97	

---oOo---